

ЦОГТ ТАЙЖ УЛААНЫ ШАШИНТАН БАЙСАН УУ?

Д.Бүдсүрэн

Удирдлагын "Соёмбо" дээд сургууль, Төрийн захиргааны удирдлагын тэнхим

e-mail: budsuren_d@yahoo.com

Өгүүллийн товч утга: Уг өгүүлэлд XVII зууны үеийн Монголын улс төр, шашны томоохон зүтгэлтэн Цогт тайж шарын шашны эсрэг тэмцэж байсан улааны шашинтан хүн байсан уу, эсвэл энэ нь Цогт тайжийн тухайн үеийн тэмцэл, үйл ажиллагаа Монголчуудын үндэсний тэмцэл болон өргөжихөөс болгоомжлон манж нарын зүгээс шарын шашнаар түрий барин буруутгасан хэрэг байсан уу гэдгийг монгол, төвд бичгийн сурвалжийн мэдээнд тулгуурлан тодруулахыг хичээсэн болно.

Түлхүүр үг: Цогт тайж, улааны шашин, шарын шашин

Орхон, Туулын бэлчир газар эзэмшил нутагтай, халхын зүүн гарт нэлээд нэр нөлөөтэй язгуурт ноён Цогт хун тайж¹ нь XVII зууны үеийн Монголын улс төр шашны томоохон зүтгэлтэн, яруу найрагч байсан бөгөөд түүний улс төрийн тэмцлийг эрдэмтэн судлаачид шашинтай холбон тайлбарласаар иржээ. Тэрбээр Монголын их хаан Лигданг тууштай дэмжиж Монголчуудын улс төрийн нэгдэл, тусгаар тогтнолыг хамгаалахын төлөө тэмцэж байсан нь түүх сурвалжид тодорхой тэмдэглэгдсэн байна.

Лигданг хаан ширээнд суусны хорин жилийн ойг тохиолдуулан хаднаа сийлүүлсэн долоон бадаг шүлэг, дагалт бичээснээ түүний улс, төр гүн ухаан, шашны баримтлал тусгалаа олсон байдаг. Цогт хун тайж улс төрийн үзэл баримтлалаасаа болж халхын ноёдтой тохирохыг больж, Лигдэн хаантай хүчээ нэгтгэхээр Хөх нуурыг зорин одсон боловч 1634 онд Лигдан хаан өвчний улмаас таалал төгссөн тул уулзаж амжаагүй ажээ. Цогт хун тайж Түмэн холачи ноёныг эрхшээлдээ оруулан, түмэдийн тархай бутархай олныг нэгтгэж "Нуурын ам" гэдэг газар суурьшсан ажээ. Улмаар Амдоогийн ихэнх нутгийг эзлэн "Хөх нуурын Цогт хаан" хэмээн алдаршин ихэд хүчирхэгжсэн бөгөөд зарим сурвалжид түүнийг дөрвөн түмэн цэрэгтэй байсан гэж тэмдэглэсэн байна.

Цогт хун тайжийн бодлого зүтгэл нь Монголыг нэгтгэхэд чиглэгдэж байсан нь тодорхой байдаг билээ.

Оросын нэрт монголч эрдэмтэн, академич Б.Я.Владимирцов "ЗХУ-ын ШУА-ийн мэдээ" сэтгүүлийн 1926-1927 онуудын дугаар дамжуулан "Халхын Цогт тайжийн хадны бичээс" хэмээх томоохон өгүүлэл хэвлүүлсэн байна. Энэхүү бүтээлдээ тэрбээр Цогтын хадны их, бага бичээсийг тайлан уншихын зэрэгцээ монгол, төвд түүхэн сурвалж хийгээд эдгээр бичээсийн мэдээ баримтад тулгуурлан Цогт хун тайжийн улс төр болон шашны үзэл баримтлалыг тодорхойлж байдаг билээ. Бид акад. Б.Я.Владимирцовын өгүүлэлд эшлэн ашигласан Лувсанчойжинямын "Дунта шэлжи мэлон", Жамбадоржийн "Болор толь", "Эрдэнэ-Зуугийн түүх" зэрэг сурвалжийн мэдээг харьцуулан нягтлахын зэрэгцээ мөн Балманбандида-ын "Энэтхэг төвд монголын түүх өчүүхэн өгүүлэх нялхасыг оруулахын буух суурь оршвой", V далай ламын "Цастан орны газраа явсан дээд язгуурт хаад түшмэдийг эрхэнд өгүүлсэн төгс төгөлдөр залуусын хурим хаврын

¹ Цогт хун тайж (1581-1637) бол Гэрсэнз Жалайр хун тайжийн гуравдугаар хөвгүүн Онохуй Үйзэн ноёны тавдугаар хүү Бахарай хошуучийн ахмад хөвгүүн бөгөөд эх нь Оннигудын нэгэн эзэн Бэрхийн охин Чин бишрэлт сайн Мадэ Тайгал хатан хөвгүүн Цогт тайжийн хамт сүм хийд байгуулах, судар ном орчуулах зэргээр Халхад шашин ном дэлгэрүүлэх хэрэгт ихэд зүтгэж явжээ.

хатны дуун эгшиг", Дармадалаа, Цэмбэл гүүш нарын "Хор чойнжүн" болон Цогтын цагаан байшингийн төвд бичээсийг биечлэн очиж хэв дардас авсан эх хэрэглэгдэхүүнийхээ мэдээ сэлтэд тулгуурлан Цогт хун тайжийн шашин, улс төрийн үзэл баримтлалыг тодруулахыг хичээлээ.

Үүний тул Монголын түүхийн зарим сурвалж бичиг болон төвд сурвалж бичигт Цогт хун тайжийн талаар ямар мэдээ байгааг авч үзье.

Жамбадоржийн "Болор толь" хэмээх түүхэн сурвалжид:

Халхын цоохор Цогт хэмээгч нэгэн гүжирмэг хүн мөн Хөх нуурын өөлдийг эзэлж, дөрвөн түмэн цэрэгтэй байсан ажгуу. Лигдан хаан бээр түүнтэй нөхцөвэй. Бас ч Пара газрын Донёд хаан хэмээгч бурхан номд дургүй байсан. Түүнтэй бас эвлэн хэлэлцэвэй. Тиймийн тул Лигдэн хаан Зан хаан, Пара хаан, халхын цоохор Цогт хэмээгч ноён энэ дөрөв нийлээд шарын шажин сүйтгэхийг завдаж байтал Сэцэн хааны наймдугаар онд дамжин Чойжилийн унтуугаар Шар тал хэмээгч газар Лигдан хаан халивай.

Энэ шажныг эвдэе гэдэг дөрвөн муу хааны Лигдан хаан, Зан-гийн хаан хоёр нь шарын шажинд үл дурлан улааны шажинд сайн бөлгөө. Пара-ийн хаан нь шажин бүхнээ сүжиггүй, бомбын номонд дуртай. Цоохор Цогт нь мөнхүү шажин бүхнээ сүжиггүй, хятадын даос-д сайн амуй. Тэр цоохор Цогт ноён болбоос урьд Лигдан хааныг ёс бус үгүй учирт Лигдан хааны харъяат монголын аймгаас олон зүйл аймаг улс зайлж халхад одсоны хойно монголын ноёд дотор зуураа тэмцэл болж, цоохор Цогт халхаас хөөгдөөд Хөх нуурын захад ирж Хошууч хэмээх ноёныг дайлаад түүний оронд эзэлж суувай.

Энэ Дээд эрдэмтийн үед тангад орны Зангийн Данжинванбу хан Бари Донёд хан, халхын цоохор Цогт энэ гурвыг эвлэж байхыг Зуу-гийн орноо Сономчоймбол гэгч мэдээд, сэмээр учрыг тодорхойлж ойрад зүүн гарын чуулганы ноёдод бичиг илгээвэй. Тэр цагт ойрад хошууд аймгийн их ноён нэр нь Төрбайх, цол нь Гүүши хан. Арвуул хамт Зуу-д мөргөх мөргөлчний байдлаар Зуу-гийн газар одож хэлэлцээд буцвай. Тэр цагт халхын цоохор Цогт өөрийн хөвгүүн Арслан хэмээгчийг түм шахам цэрэгтэй Зуу-гийн газар илгээж, тавдугаар далай ламыг хорлоор явуулбай. Тэр Арслан хэмээгч хөвгүүн нь далай ламыг үзээд сүсэглэн, хор эс хийж гэдрэг буцахын үед зангийн Шамар Равжамба Арсланы далай лам ба шажинд хор хийсэнгүй учрыг цоохор Цогтод бичиг илгээснээ эцэг нь хөвгүүндээ "Чи нааш ирж үл болох, тэндээ аргаар үхвээс болох" гэж ял илгээсэнд Арслангийн нь гүжрээр эцэс болгон, цэрэг нь хайш хэрэг болж замарвай.

Хойно Гүүши хаан бээр зүүн гарын хошууч Эрдэнэ, Баатар хун тайж нарыг дагуулж, түм шахам цэрэг аваад, Хөх нуурт хүрч одоод Гүүши хаан нэг мянган цэргээрээ цоохор Цогтын дөрвөн түмэн цэргийг Улаан хошуу хэмээгч газраа нэгэн өдөр хядаж барвай. Цоохор Цогт хэмээгч ноён ч үхвэй.²

Сүмбэ хамба Ишбалжирын "Хөх нуурын түүх" сурвалжид:

Тэр цагт Цахарын дутаасан хүн зон халхад ороход ноёд цөм сэртхийн болгоомжлов. Модон нохой жил (1634он) Цогт ноён муу самуун үүсгэснээс дотроо хямралдаж, олон халх нарт хөөгдөж, Хөх нуурт хүрч ирээд Түмэд Хулачи ноёныг харъяат албаттай нь эзлэн суужээ.³

² Жамбадорж "Болор толь". Бээжин, 1984, тал 484-489

³ Сүмбэ хамба Ишбалжир. "Хөх нуурын түүх эсэрүүгийн дуулал шинэ яруу хэмээгдэх оршвой". УБ, 1997, тал 15.

Цэмбэл гүүшийн “Монголын их гүрэнд дээдийн ном ямар мэт гарсан ёсны номлол ялгуусны шашин их эрдэнийг гийгүүлэгч зул хэмээх оршвой” сурвалжид:

Даян хааны аравдугаар хөвгүүн Гэрсэнз түүнээ долоон хөвгүүн буйн гуравдугаар Онохуй үйзэнгийн ач Цоохор Цогт хэмээх тэр бээр Халх орноосоо цөлөгдөж, Хөх нуураа ирээд, энэ хаанаа захиа илгээсэн нь: “Бидний энэ орноо эртнээс сажагийн шашин дэлгэрсэн ба өнөө маргааш гэлэгваан шашин дэлгэрэн буй болохоор үүнийг даран устгаваас сайн болмуй.” хэмээн муу зөвөлгөөн зөвшөөлийг үнэн хэмээн шамдгайлж, Зөөлөн итгэл сажа бандида бээр:

“Эрхэм буян барагдваас муу сэтгэл төржүү

Эцгийн удмыг алдваас муу үр төржүү

Эдлэл хөрөнгө барагдваас харам төржүү

Энэ насан барагдвал үхлийн ёр гармуй” хэмээн зарлигласан мэт төвдийн хаан дэсридзанба Пунцагнамжал лугаа хамсаж, шарын шашинг оргүй болгон товроглоё хэмээн тооцоолж, цэргийн өмөг лүгээ сэлт төвдийн зүгт хөдөлсөн ба Хөх нуурын хойт Ширээ талд хүрсэн үест жамбал гаадод Чойжижалба (Гэгээн Гүүши хааныг хэлж байна) бээр тонилгож, лагшин хийгээд хаан төр хоёуланг тараав.⁴

Дармадалаа-гийн “Их монгол оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оршвой” сурвалжид:

...Онохуй үйзэнгийн зургадугаар хүү Барцун хошуучийн хүү нь Хөх нуурт ирээд шарын шашныг хөнөөгч цоохор Цогт тэр мөн.

... модон нохой жилд Цогт муу ноёны дотоодын хямрал босгож, муу журам дэлгэрүүлсэн халхчууд Цогтыг өөрийн орноос цөлсөн нь Хөх нуурт очиж Түмэд Холчийг дараад Амдогийн газар орныг эзэмшээд Цогт хаан гэж алдаршин түр зуур их эрхтэй болжээ.

... Тэр мэтээр эхний Зангийн хаан шарын шашинд чухал хөнөөл учруулсан бөгөөд адгийн Бэри хаан, Цогт хоёр шарын шашинтны лам, ноёд олныг шоронд хорьж, алах зэргээр Үй, Зангийн зам хааж таслах тэргүүтэн шашинд маш хорлол үйлдэж...

...Модон гахай жилд Зангийн улаан малгайт Равжамбын заавраар Цогт хаан бээр өөрийн хүү Арслан тайжийг түм гаруй цэргийн хамтаар Үй, Зангийн шарын шашны их лам нарт хөнөөл учруулах, дацан аймгийг бусниулахын тулд заравч тэр нь төвдөд хүрээд шарын шашинтанд хорлол хүргэсэнгүй харин гал хулгана жилд Арслан тэргүүтэн нь тавдугаар Далай ламд мөргөөд их сүсэг бишрэлээр өргөл хүндлэл хийснийг Зан хааны талыг баригч улаан малгайт Равжамба тэргүүтэн сонсоод Хөх нуурт элч зарж, Арслан бээр эцэг хааны зарлиг ёсоор хийсэнгүй, шар малгайтанд хорлол, хөнөөл хийгээгүйн дээр тахил, өргөл хийж Зан хаантай дайтсан тул түүнийг хэрхэх вэ хэмээсний хариуд Цогт бээр “Чи миний хүүг аргаар алтугай” хэмээсэн ёсоор алсан учир цэрэг нь ч эзэнгүй замхруулжээ. Тэр жилд Гүшрий бээр ноён боол арваад дагуултай бурханд мөргөх байдлаар туршин шинжихийн тулд Лхасад очоод Цогтоос хүү Арслангийн цэрэг болгон явуулсан тэр цэрэгтэй нь хамт буцжээ. Гал үхэр жилийн анхдугаар сард Гүшрий хаан бээр Баатар хун тайжийг цэргийн туслахаар дагуулаад Хөх нуурын эхэнд очиж байлдаан хийсэн тул түмэн цэргээр шарын шашны дайсан Цогтын дөрвөн түмэн цэрэг бүгдийг дараад уулын хоёр хамрыг цусаар улаан болгосон учир одоо их бага улаан хошуу гэж алдаршжээ. Хүү Даян тайж тэргүүтэн бээр Цогтын цэргийн үлдэгдлийг Харгилын мөсөн дээр хүртэл хөөгөөд ялжээ. Цогт

⁴ Л.Тэрбиш, Р.Бямбаа Монголын түүх оршвой, УБ, 1997. тал 36.

хэмээн айлджээ. Төвдийн цэрэг нутаг орныг дүүрэн байсан монгол цэргийг тархааж шар болсон байна. Үүний урьд жил манан будан бүрхэж, нар цусан өнгөөр ургаж цаг самуурахын шинж үзүүлсэн хийгээд Банчэн бээр байсан ч эс бичжээ. Арслан Хондон Балжирлхүндэвээс би Хөх нуурт очоод аавтайгаа уулзаж чадах нь уу? Эви аймгуудыг нэгтгэж чадах нь уу? Бүрхэг байна уу? гэж асуусанд одоо аав чинь сайн байна. Гэвч уулзалдахгүй. Саад их байна гэжээ. Нинмаваагийн хараал гэж бодсон ч үнэн хэрэгтээ Данжанчойжал уурлаад тайж өөрөө галзуурсан бөгөөд цэргүүд нь хямрах, урвах болсон аж. Нааш ирэх үедээ Цогт Гэлүгваад уурлан эцэг хүү хоёр уулзалдахгүй байхыг бодсон ч Повонхава болон Цэрсэв дүбчин нар Жигжидийн үүднээс ууртай сэтгэлийг тайвшруулах үйлийг зохиосноор тангараглалаа. Тавдугаар далай ламыг Гандан Хансарт залж өөрөө санаа нь эргээд хэнд ч мөргөж болохгүй гэсэн дотоод цаазыг эвдэн мөргөж адис хүртэв. Харилцан ярилцаж аль нь сайн байна гэх тэргүүтэн номын яриг айлтгасан байна. Урьд монголд Содномжамц далай ламын таалал барих үед эрдэнийн “Гаачил” гараад монгол оронд шашин дэлгэрэхийн бэлгэ дэмбэрэл гарсан адил болсонд Дайчин түшмэл, шуумар Равжамба нар Цогтруу хүн илгээж хүү Арслан эцгийн зарлиг лугаа харшилсан тул яавал зохистой гэж асуулгасанд аргаар хуурч ал гэж хариулсан тул түүнийг аргаар алжээ. Гүүши хаан Дата-г номхотгон дарсан лугаа цаг нийцсэнээр Цогт сураггүй алга болсон⁸ хэмээжээ.

Тавдугаар далай ламын

གངས་ཅན་ལུ་ཁྱི་ས་ལ་སྤྱོད་པའི་མཐོ་རིས་ཀྱི་རྒྱལ་ཁུངས་ཚོ་བོར་བརྟེན་པའི་དེ་བཟེང་རྫོགས་ལྷན་གཞིན་ཀྱི་དགའ་སྟོན་བཟིང་གི་
རྒྱལ་མོའི་སྐད་བྲངས་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།། “Цастан орны газраа явсан дээд язгуурт хаад

түшмэдийг эрхэнд өгүүлсэн төгс төгөлдөр залуусын хурим хаврын хатны дуун эгшиг" сурвалжид:

སྒྲུབ་མཁུ་པོ་ཆོ་ཆོ་རྒྱལ་ལ་གཞུང་དང་ཆོངས་ཡོད་པ་རྣམས་ཆ་དཀར་རྒྱལ་པོས་བཞག་པའི་དུས་འཁྲུག་ལ་བརྟེན་གྱིས་པོ་འགའ་ཞིག་ཁར་
ཁའི་ཁོད་དུ་འོངས་པར། དཔོན་པོ་ནང་པ་རྣམས་ཚུ་ཅོད་པའི་རྒྱུ་ཁྱིམ། ཁར་ཁ་ཆོག་ལུ་རང་ལུ་ལ་ནས་སྤྱགས་ཏེ་མཆོ་ཁར་འོངས་པ། སྤྱི་གཙམ་གྱི་
ལུ་ལ་དུ་རིན་པོ་ཆའི་ཆར་བབ་པའི་གཏམ་རྒྱུད་ལྟར། རེ་གཞིག་མང་འཐང་ཆེ་བར་བྱུང་བས། བཀའ་པའི་གདོན་གྱིས་ཡིད་རྣམ་པར་བརྟམས་པས་
། བསྟན་པ་སྤྱི་དང་ཁྱེད་པར་གྱལ་བ་ཅོང་ཁ་པའི་བསྟན་པ་ལ་ལོག་པར་འཁྲུག་པའི་བསམ་སྦྱོར་རྣམས་ཉམས་སྤོངས་པ་ལ་བརྟེན་གྱིས་པོ་འདི་
ཉིད་གྱིས་བསྟན་པ་འབའ་ཞིག་ཐུགས་སུ་བཅུག་པའི། རང་ལུ་ལ་ནས་དམག་གི་དཔུང་ཆོག་མ་དང་ཆབས་གཅིག་པར་བཏོན་པ། མེ་གླང་རྒྱ་བད
ང་པོར་མཆོ་ཁར་འབྱོར་ཏེ། སྤོབས་ལྡན་གྱི་རྒྱལ་པོར་མ་ཆས་ལང་ཀའི་བདག་པོ་ལྷ་བའི་ལམ་དུ་བཏང་བ་བཞིན་ཆོག་ལུ་འདི་དམག་གི་སྤྱག་བཞི་
དང་བཅས་པ་མིང་གི་ལྷག་མར་བཏང་།

Урьд өмнө монголын зургаан их чуулганд төр ба гэрээ хэлцэл байсан бүгдийг Цахарын хаан эвдэж цагийн хямрал гарсанд шүтэж, зарим нь халхад дутаан ирж, ноёд дотор зуураа тэмцэлдсэний шалтгаанаар халхын Цогт өөрийн орноос хөөгдөж, Хөх нуурт ирэв. Хилэнцэтний оронд эрдэнийн хур буусан домог мэт Цогтын хүчин чадал нэгэн зуур их болж, хар атгагт сэтгэл нь эзлэгдэж, ер шашин хийгээд ялангуяа богд Зонхабын шашинд буруу үзлээр тэрслэх муу санаа өвөрлөснийг анхааран сэргийлэхэд дулдуйдаж, энэ хаан бээр

⁸ dbal'mang'pandi'tas'brtsams, rgya'bod'hor'sog'gi'lo'rgyus'nyung'ngur'brjod'pa'byis'pa
'jug'pa'i''bab'stegs'bzhugs'so, mtsho'sngon'mi'rigs'dpe'skrunkhang, 1990. тал 137-140.

Энд өгүүлж байгаа баримт нь итгэж үл болох зүйлийг агуулаагүй бөгөөд гүүш Цоржийн нас сүүдэртэй ч зөрчилдөхгүй байна.

Ширээт гүүш цорж гуравдугаар далай ламын гарын шавь байхын зэрэгцээ далай ламтай тэмцэж байсан улаан малгайтны сүм болох Цагаан байшингийн бичээсийн зохиогч байж болох уу? Шарын шашны дайсан Цогт хун тайж энэ хийдийг барьсан нь гарцаагүй үнэн билээ. Цогт хун тайж Цахарын Лигдэн хааныг Хөх нуур дахь шар малгайтнуудын эсрэг тэмцэлд уриалахад тийм их үүрэг гүйцэтгэсэн гэж үү? Цогт хун тайж Цахарын хаант улсын мөхлийн буруутан нь үнэхээр мөн юм уу? Бусад сурвалжууд бидэнд өөр дүр зургийг харуулж байгаа билээ.

“Милрайбын намтар”¹²-ын монгол хувилбарын төгсгөлийн үгэнд: (Бээжин барын 233-335)

1. Үндсэн тэр богдын туужийг нь
Өмнөт энэ монгол улсад нь
Урьд эс алдаршсаны тулд нь
Орчуулбаас их төв улсад нь
2. Бурханы шашин дэлгэрүүлэхийн тул дурдсан
Бүгдээрт нэр алдрыг маш туулсан
Будангуй үйлийг сайтар тэвчсэн
Буянт Чин тайху хатан хэмээгдсэн
3. Гэгээн оюун билиг сайтар төгссөн
Хэллэшгүй чанарыг огоот ухсан
Хэлбэрэхгүй номын үйлийг хийсэн
Хэтэрхийеэ Цогт хун тайж хэмээн алдаршсан
4. Эх хөвгүүн хоёул чин зориг сэтгэлээр
Өдүүлж орчуул хэмээн дурдсанаар
Эрдэнэ цогцолсон энэ туужийг оршуулснаар
Эгнэгт хамагт тус болмуй хэмээн сэтгэснээр
5. Бас бас сайтар урнаа найруулж
Баршгүй номын чанарыг төгсгөж
Балан монголын аялгуугаар сайтар тохиолдуулж
Бандида Ширээт Цорж орчуулбай монголчлон найруулж

Хотол дахь газраас чин сүсэг сэтгэлээр энэ туужийг орчуулан залж ир хэмээн илгээсэн элч нь, Хөндлөн холчи чинсан, Эрдэнэ номч Сандин, Зоригт хиа эд гурвуулыг илгээсэн бөлгөө. Уу морин жилийн цагаан сарын тэргэл өдөр. Хамагт алдаршсан Хөх хотын өмнө дахь, Номт төв нэрт харшид төгсөөр оршуулан орчуулбай” гэжээ.

“Болор толь”, “Дунта шилжи мэлон”-гийн зохиогчийн нэг адилаар “Хор чойнжүн”-гийн зохиогчид нь манжийн эзэн хаан болон монголын эрхтэн дархтнуудын талыг баримталж шарын шашны гол өмөг түшиг болж байсан тэдгээр хаад ноёдын талыг баримталсан шар малгайтны урсгалын лам санваартнуудын тэрхүү орчинд хамаарч байлаа. Монголын ноёд язгууртнуудын эдийн засгийн ашиг сонирхол ялангуяа өмнөд монголын лам нар манжийн хаан болон түүний засаг захиргааг Зонховын шарын шашны сүм хийдийг цэцэглүүлэн хөгжүүлэх хамгийн гол түшиг тулгуур гэж үзэж байжээ. Манзушрийн хувилгаан болох манжийн эзэн хаан нь бурханы шашны ганцхан ивээн тэтгэгч, сахин хамгаалагч, асран нигүүлсэгч учраас нэгэн үндэстний бус бүхий л үндэстнүүдийн хувьд нэгэн адил буддын шашны бодлогыг баримтлах ёстой хэмээн үзэж байлаа.

¹² Б.Я.Владимирцов. “Надписи на скалах халхаского Цокту-тайджи” Известия Академии Наук СССР. 1927, стр 220 (дам эшлэв)

Энэхүү далай ламын шавь гүүш Цорж Хөх хотын сүм хийдэд шар малгайтнуудын өмөг түшгийн дор олон жил сууж шарын шашны сүм хийдээс хүлээж авсан олон орчуулгын зохиогч болж халх дахь Эрдэнэ-Зуугийн ширээт лам болсон байж болох бөгөөд улаан малгайтны хийдэд зориулан босгосон бичээсийн зохиогч гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Гэвч XVII зуунд халхад улааны болон шарын шашны баримтлагчдын хоорондын хэрүүл маргаан нь өөр хоорондын дайн самуунд хүрч, улмаар шүтлэг бишрэлийнхээ төлөөх улаан малгайтнуудын сүм хийдийн эвдрэл сүйрлээр төгссөн юм гэсэн баталгаанд ихээхэн эргэлзээтэй хандах хэрэгтэй юм.

Бидний үзэж мэдсэнээр Хөх хотруу элч илгээхтэй давхцсан Цогт хун тайж, гүүш Цорж хоёрын харилцааны түүх нь ихээхэн сонирхолтой юм. Учир нь Цогт хун тайж шарын шашны улайрсан дайсан байсан мэт хожмын төвд монгол сурвалж бичгүүдийн мэдээллийг энэ нь няцааж байгаа юм. XVII зууны үеийн бүх монголчуудын түүхийн хувьд тэрбээр бурханы шашныг илтэд өмгөөлөгч, сүм хийд барьж байгуулагч, бурханы шашны ном зохиолын орчуулгыг сэтгэл харамгүй захиалагч байсан билээ.

Эцэст дүгнэн хэлэхэд, XVII зууны үеийн Монгол оронд шашны хоёр урсгал эвтэй найртай хамтран оршиж, шарын шашны сүм хийд нь улааны шашны лам нарыг урин залж, улааны сүм хийдийн өмгөөлөгч ноёд шарын сүм хийдийн эрдэмт лам нарт хандаж ном судар орчуулагдах хүсэлт гаргаж байсан нь Цогт хун тайж, тухайн үеийн шарын шашны томоохон төлөөлөгч болох гүүш Цорж нарын харилцаанаас тодорхой байна. Иймд Цогт хун тайжийг шарын шашны эсрэг, улааны шашныг хамгаалан тэмцэгч байсан мэтээр өгүүлэх нь түүхийн бодит байдалд огт нийцэхгүй байгааг тэмдэглэе.

Abstract: The main objective of the research work was to identify that the Prince Tsogt Taij, Political and Religious Leader of 17th century was really a member of the Red Buddhist against the Yellow Buddhists or a nobleman, who is criticized by the Manchu people, caused anxiety that the Prince Tsogt Taij's activities strengthen the Mongol's National Revolution, based on the historical facts in Mongolian and Tibetan languages.

According to this research, we found out that Tsogt Taij had friendly relations to the Yellow Buddhist and also it is known that Tsogt Taij had peaceful relations to the Guush Tsorj, the Religions Leader of the Yellow Buddhists, used to invite each other and the Red Buddhists requested the Yellow Buddhists to translate sutras.

Therefore, we considered that the Prince Tsogt Taij was not agained the Yellow Buddhists and not only a guardian of the Red Buddhists in Mongolian history.

Ашигласан ном зохиол

1. Монгол улсын түүх, дөтгөөр боть, УБ., 2003
2. Монгол улсын түүх, гутгаар боть, УБ., 2003
3. Бүрнээ.Д, Энхтөр.Д, Монголын бурханы шашны түүхэн сурвалж, УБ, 2004
4. Бүрнээ.Д, Энхтөр.Д, Төвд монгол толь бичиг, УБ., 2001
5. Владимирцов.Б.Я, "Надписи на скалах халхаского Цокту-тайджи" Извения Академии Наук СССР.1926, 1927
6. Гонгор.Д, Халх товчоон I, УБ., 1970
7. Дармадалаа, Их Монгол оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оршвой, УБ.,1995
8. Jimbadorji, "Bolor toli", Лиү Жин Со хянаж тайлбарлав, Үндэстний хэвлэлийн хороо, Хөх хот, 1984
9. Сүмбэ хамба Ишбалжир, Хөх нуурын түүх эсэрүгийн дуулал шинэ яруу хэмээгдэх оршвой, УБ., 1997
10. Цогт хун тайжид холбогдох бичгийн дурсгалууд, УБ., 2005
11. Тэрбиш.Л, Бямбаа.Р, Монголын түүх оршвой, УБ., 1997
12. dbal'mang'pandi'tas'brtsams, rgya'bod'hor'sog'gi'lo'rgyus'nyung'ngur'brjod'pa'byis'pa 'jug'pa'i'bab'stegs'bzhuks'so, mtsho'sngon'mi'rigs'dpe'skrun'khang, 1990